


НИЙГМИЙН ХӨГЖИЛД НИЙСЛЭЛ ХОТЫН ЭЗЛЭХ БАЙР СУУРЬ

Монгол улсын нутаг дэвсгэрт оршин суугаа хүн амын 44.8 хувь буюу бараг 2 хүн тутмын нэг нь нийслэл хотод оршин сууж байна. Нийслэлийн хүн амын 94.9 хувь нь төвийн 6 дүүрэгтээ, тодруулбал зүүн хэсэгт орших Баянзүрх дүүрэгт 23.5 хувь, баруун хэсэг Сонгинохайрхан дүүрэгт 22.5 хувь, хотын төв Баянгол дүүрэгт 15.9 хувь, баруун хойт хэсгийн Чингэлтэй дүүрэгт 12.1 хувь, баруун өмнөд хэсэгт орших Хан-Уул дүүрэгт 10.5 хувь, зүүн хойт хэсгийн Сүхбаатар дүүрэгт 10.4 хувь, үлдсэн 5.1 хувь нь Налайх, Багануур, Багахангай дүүрэгт тус тус амьдарч байна.

Зураг 1. Монгол улсын хүн ам, бүсээр



Зураг 2. Хүн амын тархалт, дүүргээр



2000 онд нийслэлийн нэг км² нутаг дэвсгэрт 162 хүн оршин сууж байсан бол 2001 онд 168 хүн, 2002 онд 175 хүн, 2003 онд 185 хүн, 2004 онд 195 хүн, 2005 онд 202 хүн, 2006 онд 210 хүн, 2007 онд 218 хүн, 2008 онд 227 хүн, 2009 онд 235 хүн, 2010 онд 247 хүн, 2011 онд 252 хүн, 2012 онд 259 хүн, 2013 онд 269 хүн, 2014 онд 279 хүн оршин суух болжээ. Улаанбаатар хотын хүн амын нягтрал 2011-2014 оны хооронд 10.7 хувиар өсчээ.

Хүснэгт 1. Суурин хүн амын тоо, хүн амын нягтрал, дүүргээр


Дүүрэг	Нутаг дэвсгэр /км ² /	Хүн амын тоо /мян.хүн/				Хүн амын нягтрал, нэг км ² -д			
		2011 он	2012 он	2013 он	2014 он	2011 он	2012 он	2013 он	2014 он
Нийслэлийн дүн	4704.4	1206.6	1227.0	1267.0	1314.5	252	259	269	279
Баянзүрх	1244.1	283.3	294.9	304.3	308.7	221	232	245	248
Сонгинохайрхан	1200.6	257.2	261.9	277.3	295.8	212	216	231	246
Баянгол	29.5	192.1	192.6	200.2	208.9	6393	6521	6785	7081
Чингэлтэй	89.3	153.1	153.9	155.9	159.5	1683	1719	1745	1786
Хан-Уул	484.7	119.9	127.5	131.1	138.4	239	255	270	285
Сүхбаатар	208.4	137.8	132.1	133.3	136.4	659	648	640	655
Налайх	687.6	32.5	32.9	33.2	34.6	47	48	48	50
Багануур	620.2	27.0	27.5	27.9	28.3	43	44	45	46
Багахангай	140.0	3.7	3.7	3.8	3.9	26	26	27	28

Хүн амын нягтрал Баянгол /7081/, Чингэлтэй /1786/, Сүхбаатар /655/ дүүрэгт хамгийн их буюу нийслэлийн дунджаас 2.3-25.4 дахин их байна. Харин захын 3 дүүрэг Налайх /50/, Багануур /46/, Багахангай /28/-д хүн амын нягтрал хамгийн бага байгаа юм.

Зураг 3. Хотуудын хүн амын эзлэх хувь

Улаанбаатар хот Монгол улсын нутаг дэвсгэрийн дөнгөж 0.3 хувийг эзэлж, хүн амын нягтралаар хамгийн өндөр хот хэвээр байна.

Монгол улсын нутаг дэвсгэрт оршин суугаа хүн амын 66.4 хувь буюу 1950.8 мянга нь хотын хүн ам буюу аймгийн төв, нийслэл, тосгоны хүн ам юм. Хотуудын хүн амын 67.4 хувь буюу гуравны хоёр хувь нь нийслэл Улаанбаатар хотод оршин сууж байна.



Нэг км² газарт ногдох хүний тоо буюу хүн амын нягтрал нийслэл хотод 279 хүн байгаа нь Монгол улсын томоохон суурин газар болох Орхон /нягтрал 118/, Дархан-Уул /нягтрал 30/ аймгаас даруй 2.4-9.3 дахин их нягтралтай байна.

Хүснэгт 2. Нийслэлийн хороод, хүн амын тоогоор

Бүлгийн интервал	Бүлэгт хамаарах хорооны тоо	Бүлгийн хүн амын тоо	Дүнд эзлэх хувь
600-5000	21	74354	5.7
5001-6500	27	156550	11.9
6501-8000	25	182427	13.9
8001-10000	31	272354	20.7
10001-12000	21	230291	17.5
12001-15000	15	199639	15.2
15001+	12	198871	15.1

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2010 оны 6/48 дугаар тогтоолоор иргэдэд төрийн үйлчилгээг шуурхай хүргэх нөхцлийг бүрдүүлэх зорилгоор өрх, хүн амын тоо, газар нутгийн хэмжээг харгалзан 2011 оноос 20 хороо шинээр байгуулж нийтдээ 152 хороотой болсон. Шинээр 20 хороо нэмж байгуулахдаа хуучин үйл ажиллагаа явуулж байсан 132 хорооны 28 хорооноос өрх, хүн амын тоо, газар нутгийг салган өөрчлөлт оруулснаас гадна 4 хорооны өрх, хүн амын тоо, газар нутгийн хэмжээнд зохицуулалт хийсэн.

Нийслэл хот засаг захиргааны анхан шатны 152 нэгжтэй болсноор нэг хороонд дунджаар 8648 хүн оршин сууж байгаа нь нийслэлээс бусад аймгуудын нэг сумын дундаж хүн амын тооноос 1.8 дахин илүү байна.

Нэг хороонд оршин суух дундаж хүн амын тоо 8648 болж өмнөх оноос 312 хүнээр илүү болжээ. Нэг хороонд оршин суудаг хүн амын тоогоор Сонгинохайрхан, Баянгол, Баянзүрх дүүргүүд тэргүүлж байна. Нийслэл хотын хамгийн их хүн амтай Баянзүрх дүүргийн 5-р хороонд 18834 хүн, харин хамгийн бага хүн амтай Багануур дүүргийн 2-р хороонд 641 хүн оршин суудаг.

2014 онд Улаанбаатар хотод 37322 эхээс, 37672 хүүхэд төрж, 7608 хүн нас барж, ердийн цэвэр өсөлтөөр 30064 хүнээр нэмэгдсэн байна. Цэвэр өсөлтөд нийслэл хотын эзлэх хувийн жин 2010 оны байдлаар 43.9 хувьтай байсан бол жил ирэх тусам нэмэгдсээр 45.3 хувьтай болоод байна.

Хүснэгт 3. Хүн амын цэвэр өсөлт

		2009 он	2010 он	2011 он	2012 он	2013 он	2014 он
Улаанбаатар	Төрсөн хүүхдийн тоо	27946	26828	30226	33324	36421	37672
	Нас барсан хүний тоо	6310	7064	7768	7554	7068	7608
	Хүн амын цэвэр өсөлт	21636	19764	22458	25770	29353	30064
Улсын дүн	Төрсөн хүүхдийн тоо	69167	63270	69853	73839	79780	82839
	Нас барсан хүний тоо	16911	18293	19155	17761	17247	16521
	Хүн амын цэвэр өсөлт	52256	44977	50698	56078	62533	66318
Цэвэр өсөлтөд нийслэл хотын эзлэх хувийн жин		41.4	43.9	44.3	46.0	46.9	45.3


Төрөлтийн ерөнхий коэффициент буюу 1000 хүн амд ногдох төрөлт 29.2 болж 2010 оноос 5.5 промилээр өсч, харин нас баралтын ерөнхий коэффициент буюу 1000 хүн амд ногдох нас баралт 5.9 болж 2010 оноос 0.3 промилээр буурчээ.

Хүснэгт 4. Төрсөн хүүхдийн тоо, дүүргээр, 2009-2014 он

Дүүрэг	2009 он	2010 он	2011 он	2012 он	2013 он	2014 он
Багануур	671	631	657	753	850	762
Багахангай	84	91	98	103	106	109
Баянгол	4116	3803	4452	5002	5543	5803
Баянзүрх	6244	6134	6941	7530	8310	8404
Налайх	814	796	881	874	968	947
Сонгинохайрхан	6329	6155	6883	7502	8171	8688
Сүхбаатар	3281	2967	3242	3430	3914	3889
Хан-Уул	2657	2657	3112	3471	3999	4450
Чингэлтэй	3750	3594	3960	4659	4560	4620
Нийслэлийн дүн	27946	26828	30226	33324	36421	37672
Улсын дүн	69167	63270	69853	73839	79780	82839
Улсын дүнд эзлэх хувь	40.4	42.4	43.3	45.1	45.7	45.5

Улаанбаатар хотод 2014 онд 37672 хүүхэд мэндэлсэн нь 2010 оноос 10844 хүүхдээр буюу 40.4 хувиар илүү байна. Нийт төрсөн хүүхдийн 2.9 хувь буюу 1071 нь 19 хүртэл насны эхээс, 22.2 хувь буюу 8363 нь 20-24 насны эхээс, 31.9 хувь буюу 12025 нь 25-29 насны эхээс, 23.5 хувь буюу 8855 нь 30-34 насны эхээс, 14.0 хувь буюу 5272 нь 35-39 насны эхээс, 4.8 хувь буюу 1809 нь 40-44 насны эхээс, 0.7 хувь буюу 277 нь 45-аас дээш насны эхээс тус тус мэндэлжээ. 20-24 насны 1000 эмэгтэй тутмаас 136 хүүхэд, 25-29 насны 1000 эмэгтэй тутмаас 151 хүүхэд, 30-34 насны 1000 эмэгтэй тутмаас 135 хүүхэд, 35-39 насны 1000 эмэгтэй тутмаас 92 хүүхэд төрсөн байна.

Зураг 4. Хүүхэд төрүүлсэн эхчүүд, боловсролын төвшнөөр



2014 онд хүүхэд төрүүлсэн эхчүүдийг боловсролын төвшнөөр нь авч үзвэл 52.4 хувь буюу 19565 нь дээд болон түүнээс дээш, 40.3 хувь буюу 15020 нь бүрэн дунд, 3.8 хувь буюу 1434 нь суурь, 3.1 хувь буюу 1137 нь тусгай мэргэжлийн дунд болон техникийн мэргэжлийн, 0.3 хувь буюу 114 нь бага боловсролтой, үлдсэн 0.1 хувь буюу 52 нь ямар нэг боловсролгүй, эмэгтэйчүүд байна.

Хүүхэд төрүүлсэн эхчүүдийн 9.1 хувь буюу 3392 нь гэр бүлгүй, 90.9 хувь буюу 33930 нь гэр бүлтэй бөгөөд тэдний 57.0 хувь нь гэр бүлээ албан ёсоор батлуулжээ.

ХҮН АМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Нийслэл хотын иргэдэд 2014 оны байдлаар эрүүл мэндийн салбарын үйлчилгээг 1612 байгууллагын нийт 23.9 мянган мэргэжилтнүүд үзүүлж байна. Тухайлбал 5793 их эмч, 1208 эм зүйч зэрэг 9953 дээд мэргэжлийн, 267 бага эмч, 466 лаборант, 336 гэрлийн техникч, 829 эм найруулагч, 5598 сувилагч, 265 эх баригч зэрэг 8075 дунд мэргэжлийн, бусад мэргэжлийн 5895 ажилчид ажиллаж, ард иргэдэд эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлж байна.

Хүснэгт 5. Эрүүл мэндийн байгууллагын тоо


	2009 он	2010 он	2011 он	2012 он	2013 он	2014 он
Төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв	16	16	16	16	16	13
Дүүргийн нэгдсэн эмнэлэг	12	12	12	12	12	12
Амаржих газар	3	3	3	3	3	3
Өрхийн эмнэлэг	124	123	124	131	136	134
Хувийн эмнэлэг	835	848	860	675	631	751
Рашаан сувилал	3	2	48	66	45	73
Эмийн сан	378	360	374	477	373	469

Улсын хэмжээнд эрүүл мэндийн байгууллагад ажиллагсдын 51.9 хувь буюу 23.9 мянган хүн Улаанбаатар хотын эрүүл мэндийн байгууллагуудад ажиллаж байна. Мөн их эмч нарын 62.3 хувь, эм зүйч нарын 75.0 хувь, эмнэлгийн дунд мэргэжлийн ажилтны 44.1 хувь нь тус тус нийслэл хотод ажиллаж байна.

Хүснэгт 6. Эрүүл мэндийн байгууллагын ажиллагчдын тоо

Мэргэжил	2009 он	2010 он	2011 он	2012 он	2013 он	2014 он
Бүгд	18950	19383	20644	22399	23160	23923
үүнээс: эмэгтэй	16220	16361	17393	18510	18868	19724
Их эмч: Бүгд	4328	4565	4907	5359	5510	5793
үүнээс: эмэгтэй	3443	3638	3919	4217	4277	4709
Дотрын	496	469	541	544	569	708
Мэс заслын ба гэмтлийн	314	324	352	384	398	421
Эх барих эмэгтэйчүүдийн	333	353	373	406	418	419
Хүүхдийн	290	264	284	321	318	317
Халдвартын	153	169	187	147	146	125
Хавдар судлалын	41	46	44	43	43	36
Нүдний	85	94	90	85	104	97
Чих, хамар, хоолойн	73	85	75	95	89	86
Сүрьеэгийн	52	56	57	60	57	60
Арьсны	91	88	82	85	95	97
Рентгений	195	203	218	237	263	290
Мэдрэл, сэтгэл мэдрэлийн	238	245	273	280	272	301
Физик эмчилгээний	82	65	77	87	106	95
Стоматологийн	387	387	483	561	538	701
Лабораторын	178	195	205	232	239	228
Бусад мэргэжлийн	1320	1522	1566	1792	1855	1812
Эм зүйчид	889	925	1004	1153	1248	1208

Зураг 5. Нэг их эмчид ногдох хүний тоо, аймаг, нийслэлээр



2014 оны байдлаар нэг их эмчид 224 хүн, нэг сувилагчид 232 хүн ногдож байгаа нь бусад бүс нутаг, аймгуудаас ажлын ачаалал нь харьцангуй бага байна.

Хүснэгт 7. Эмнэлгийн дунд мэргэжилтний тоо

Мэргэжил	2007 он	2008 он	2009 он	2010 он	2011 он	2012 он	2013 он	2014 он
Бүгд	6332	6868	6799	6604	7063	7563	7826	8075
Бага эмч	312	293	294	293	305	237	231	267
Эм найруулагч	772	1089	1114	1117	1171	1291	1396	829
Лаборант	362	377	375	385	412	431	451	466
Сувилагч	4023	4211	4240	4396	4671	5003	5056	5598
Рентгений техникч	97	106	99	99	98	114	129	336

2014 онд улсын хэмжээнд 772.2 мянган хүн хэвтэж эмчлүүлсний 51.2 хувь буюу 395.8 мянган хүн Улаанбаатар хотын эмнэлгүүдэд хэвтэн эмчлүүлжээ. Эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн хүмүүсийн 27.6 хувь нь дотрын, 7.8 хувь нь мэс заслын, 16.6 хувь нь төрөх, 4.0 хувь нь эмэгтэйчүүдийн, 12.7 хувь нь хүүхдийн тасгаар эмчлүүлсэн байна.

Хүснэгт 8. Эрүүл мэндийн салбарын зарим үзүүлэлтүүд

	2009 он	2010 он	2011 он	2012 он	2013 он	2014 он
Их эмчийн тоо	4328	4565	4907	5359	5510	5793
1 их эмчид ногдох хүний тоо	251	267	240	227	229	224
Эмнэлгийн орны тоо	8168	8187	9044	9456	9685	10614
1 оронд ногдох хүний тоо	133	138	131	129	129	122
Хэвтэж эмчлүүлсэн өвчтний тоо	293347	314717	333326	355218	370873	394989
Нялхсын эндэгдэл	545	487	450	486	546	625
Эхийн эндэгдэл	24	14	15	16	21	15
Үр хөндөлт	7462	8214	12338	13895	10385	11900

Зураг 6. Нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд



Нийслэл хотод 2014 онд нэг хүртэл насны хүүхдийн эндэгдэл 625, эхийн эндэгдэл 15 гарчээ. Амьд төрсөн 1000 хүүхэд тутмаас нэг хүртэл насандаа эндсэн хүүхдийн тоо 16.6 болж өмнөх оноос 1.6 промилээр өсч, харин 2010 оноос 1.6 промилээр буурчээ.

2014 оны байдлаар эхийн эндэгдлийн 60.0 хувь, нэг хүртэл насандаа эндсэн хүүхдийн 50.0 хувь, халдварт өвчнөөр өвчилсөн тохиолдлын 55.7 хувь нь нийслэл Улаанбаатар хотод гарсан байна.

2014 онд халдварт өвчнөөр өвчилсөн 18653 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оноос 0.5 хувь буюу 86 тохиолдлоор, 2010 оноос 12.9 хувь буюу 2771 тохиолдлоор тус тус буурсан байна.

Хүснэгт 9. Бүртгэгдсэн халдварт өвчин

	2009 он	2010 он	2011 он	2012 он	2013 он	2014 он
Халдварт өвчнөөр өвчилсөн бүх хүн, үүнээс:	18526	21424	19955	25128	18739	18653
Вируст хепатит	2488	2630	4768	2718	1207	603
Менингит	11	11	9	14	17	5
Цусан суулга	2382	2797	1707	1726	1573	1921
Салхин цэцэг	640	739	1740	1578	2552	2305
Гахайн хавдар	1435	169	477	6968	1487	188
Сальмонеллэз	92	108	77	78	49	72
Улаан эсэргэнэ	17	20	57	88	259	270
Хоолны хордлого	92	329	147	633	121	235
Ёлом	126	125	123	145	109	104
Улаанууд	3	8	15	204	9	1
Бруцеллэз	56	165	63	34	14	17
Гар хөл амны өвчин	187	1382	700	377	1262	1614
Тэмбүү	2476	2229	2378	2764	3269	3618
Заг хүйтэн	2273	2272	1976	2219	1767	1650
Трихомониаз	2239	1820	1683	2030	1850	1723
Шинээр илэрсэн сүрьеэ	2390	2341	2283	2261	2401	2544
ХДХВ/ДОХ	13	21	17	27	23	31
Улсын хэмжээнд бүртгэгдсэн халдварт өвчин	38859	41373	42839	43305	37318	33516
Улсын хэмжээнд эзлэх хувь	47.7	51.8	46.6	58.0	50.2	55.7

Зураг 7. Халдварт өвчнөөр өвчлөгсөд



10000 хүн тутмаас халдварт өвчнөөр өвчилсөн хүний тоо өмнөх оноос 5.8 продици-милээр, 2010 оноос 44.4 продицимилээр тус тус буурчээ.

Халдварт өвчнөөр өвчлөгс-дийн 19.4 хувийг тэмбүү, 13.6 хувийг шинээр илэрсэн сүрьеэ, 12.4 хувийг салхинцэцэг, 10.3 хувийг цусан суулга, 9.2 хувийг трихомониаз, 8.8 хувийг заг хүйтэн, 8.7 хувийг гар хөл амны өвчнөөр өвчлөгсөд тус тус эзэлж байна.